

## ОЮУТНЫ БИЕ ДААЛТЫН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ТЕХНОЛОГИЙН КАРТ АШИГЛАХ НЬ

*Г.И. Вергелес, О.А. Граничина, Герценовские чтения. Начальное образование, Издательство: ООО «ВВМ» (Санкт-Петербург)*

**Хураангуй:** Дээд боловсролын улсын шинэ стандартыг хэрэгжүүлэх шилжилт оюутны бие даан сурах түвшнийг дээшлүүлэх, тэднийг өөрөө боловсрол олж авахад бэлтгэхэд чиглүүлж байгаа тухай өгүүлэлд харуулжээ.

Оюутны бие даалтын ажлыг зохион байгуулахад технологийн картыг ашиглахад тавих шаардлагыг авч үзсэн.

**Түлхүүр үгс:** бага боловсролын салбарт мэргэжилтэн бэлтгэх, бие даалтын ажил, бие даах чадвар, хувийн зохион байгуулалт, оюутны үйл ажиллагааг удирдах, технологийн карт.

Орчин үеийн дээд боловсролын чанар, түүний үр ашгийг дээшлүүлэх нь Оросын нийгэм, төр улсын хөгжил, дэлхий дахинд нэр төртэй байр суурь эзлэн байж чадах эсэх нь хамаарах тулгамдсан үндсэн асуудлын нэг юм. Энэ үйл явцад багш (сурган хүмүүжүүлэх) боловсрол онцгой үүрэгтэй бөгөөд дээд боловсролын бүхий л тогтолцооны хөгжилд хэрэгтэй гарааны түвшнийг чухамхүү багшийн бэлтгэгдсэн түвшин л хангана.

А.П. Тряпицына, Н.Ф. Радионова нар багш (сурган хүмүүжүүлэх) боловсрол нь “мэргэжлийн боловсролын бие даасан төрөл төдийгүй, улс орны боловсролын бүхий л тогтолцоог үүсгэн бүрдүүлэгч байж, боловсролын бусад төрөл, түвшнээс түрүүлж” хөгжих ёстой хэмээн бичсэн нь шударга үнэнд нийцнэ (Тряпицына, Радионова, 2008, 22).

Дээд боловсролын улсын шинэ стандартыг мөрдөж хэрэгжүүлэх болсон өнөө үед боловсролын салбарт мэргэжлийн чадамж бүхий мэргэжилтэн бэлтгэхийн тулд юуны өмнө ирээдүйн багшийн бие хүний (личности будущего учителя) хөгжил, түүний боловсрол эзэмшилтийн түвшин, багшлах (сурган хүмүүжүүлэх) чиг хандлага, нийгэм, улсын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн түргэн шуурхай зохицох, сэтгэл судлал - сурган хүмүүжүүлэх ухааны ололтыг мэдэрч ашиглах овсгоотой болгоход анхаарах ёстой нь илт болов (Вергелес, 2011).

Багш бэлтгэх үйл явцын чанарыг дээшлүүлэх гэдгийг хэрэглэгчдийн захиалга, эрэлт хэрэгцээнд нийцэх хэр хэмжээ хэмээн авч үзвэл энэ нь тухайн үйл явцыг бүрдүүлж буй бүтцийн бүх хэсэг болох:

бэлтгэх үйл явцын удирдлагын чанар, сурган заах чанар, сургалтын агуулгын чанар, ашиглаж буй технологийн чанар зэргийг төгс боловсронгуй болгож байж сая боломжтой болно (Граничина, Трапицын, 2007, 9). Өөрөөр хэлбэл, хэрэглэгчид буюу оюутан, тэдний эцэг эх, ажил олгогч, төр, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэхийн тулд багш бэлтгэх үйл явцыг бүрдүүлж буй бүх бүрдэл хэсэг эцсийн бүлэгт мэргэжилтний чадамж, боловсрол эзэмшилтийн илүү өндөр түвшин хангахуйцаар өөрчлөгдөж байж уг үйл явцын чанарыг дээшлүүлэхэд мэдэгдэхүйц ахиц гарна. Тийм учраас дээд боловсролын тогтолцоонд янз бүрийн чиглэлээр ажил зохиож байгаагийн нэг нь технологи, тэгэхдээ юуны өмнө бие даан ажиллах хүсэл тэмүүлэл, бэлэн байдлыг амжилттай төлөвшүүлэхүйц технологийг төгс боловсронгуй болгох явдал юм. Эдгээр зорилгыг хэрэгжүүлэхэд Болоны үзэл баримтлалын хүрээнд багш (сурган хүмүүжүүлэх) боловсрол олон шатлалт тогтолцоонд шилжих болсноор хувийн жин, ач холбогдол нь улам бүр өсөн нэмэгдэж буй (бакалавр бэлтгэх бүтцэд бие даалтын ажил цагийн 50%, магистрантурт -75% ногдох болсон) оюутны бие даалтын ажлын зохион байгуулалтыг хангахуйц технологи боловсруулах явдал чухал байр эзэлж байна. Хүн төрөлхтөн “насан туршийн боловсрол”-ын эринд шилжиж байгаа болохоор энэхүү чиг хандлага цаашид тууштай хадгалагдах нь ойлгомжтой юм. Тиймээс ирээдүйн мэргэжилтэн оюутны ширээнд сууж байхдаа сурахуйд суралцах, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх бүхий л он жилүүдийн туршид өөрийнхөө оюуны нөөцийг баяжуулан зузаатгах тууштай хэрэгцээг олж авах ёстой.

Оюутны бие даалтын ажлыг үр ашигтай зохион байгуулахад боловсролыг тасралтгүй эзэмших субъектив бэлэн байдал, шаардлага гарсан үед шинэ чиглэлийн мэргэшил, зарим тохиолдолд бүр цоо шинэ мэргэжил эзэмших тодорхой чадал тэнхээ төлөвшүүлж, суулгадаг. Оюутан бие дааж амжилттай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх нь ямар ч мэргэжилтэн бэлтгэхэд маргашгүй чухал. Энэ асуудал мэргэжлийн багш (сурган хүмүүжүүлэгч) бэлтгэхэд бүр ч онцгой ач холбогдолтой бөгөөд ийм нөхцөл бүрдсэн тохиолдолд багш хэрэгтэй хэрэггүй үй түмэн мэдээллээс гарцаагүй хэрэгтэй

шинийг олж харах мэдрэмжтэй байх төдийгүй өөрийн шавь нарыг тасралтгүй боловсрол олж авахад бэлэн байх үндсийг төлөвшүүлж чаддаг болно.

Оюутны бие даан сурах ажлын амжилттай байх эсэх нь юуны өмнө мэргэжлийн мэргэжилтэн болж төлөвшихөд бие даан ажиллахын ач холбогдлыг хэр зэрэг ухамсарлаж ойлгосноос, багшлах (сурган хүмүүжүүлэх) үйл ажиллагаанд сэтгэл зориг шулуудсан, эс шулуудсан байдлаас хамаарна. Тийм учраас их дээд сургуулийн нийт багш нарын хүчин чармайлт нь: мэргэжлийн үйл ажиллагаанд хандах оюутны эерэг чиг хандлага төлөвшүүлэхэд, хувийн хичээл зүтгэлгүйгээр, эмх цэгцтэй (системтэй) тууштай ажиллахгүйгээр чадамжтай мэргэжилтэн болж чадахгүй гэдгийг ухамсарлуулахад гол төлөв чиглэх ёстой.

Сэтгэл судлал - сурган хүмүүжүүлэх ухаанд бие даалтын ажлыг шинжлэх ухааны судалгааны объект (феномен) талаас нь маш эртнээс судалсаар ирсэн (С.И. Архангельский, Б.П. Есипов, Н.Г. Казанский, Т.С. Назарова, П.И. Пидкасистый болон бусад). Өнөөдөр бие даалтын ажлыг чиглэсэн зорилготой, сэдэл тэмүүлэлтэй, бүтэцчилэгдсэн, явц, үр дүнгээр нь засвар өөрчлөлт оруулдаг субъектын өөрийнх нь үйл ажиллагаа хэмээн үзэж байна (А.И.Зимняя). Оюутны бие даалтын ажлын чанар нь түүний мэргэшсэн удирдлагаар, өөрөөр хэлбэл бие даалтын ажлын үндэс болсон ерөнхий болон тодорхой чадвар, оюуны үйлийг зорилго чиглэлтэйгээр (ялангуяа эхний үе шатанд) төлөвшүүлснээр хангагдана. Оюутан бие даалтын ажлыг гүйцэтгэж эхлэхдээ юу хийх ёстойгоо мэдэхээс гадна түүнийг хийж чаддаг байх ёстой, өөрөөр хэлбэл, үйлдлийн шаардлагатай системийг эзэмшсэн байх ёстой бөгөөд бие даан ажиллах явцад энэ нь мэдээж хэрэг төгөлдөршинө.

Оюутнуудыг бие даах үйл ажиллагаанд татаж оруулахын тулд технологи талаас нь хангах, өөрөөр хэлбэл, тэдгээрийн үйл ажиллагааг удирдах, боловсролын төвлөсөн үр дүнд хүрэх нөхцөлийг бүрдүүлэх, гүйцэтгэх ажлын төрөл, эрэмбэ дараалал, үнэлгээний шалгуурыг хатуу тогтоох ёстой.

Энэ бүхэн Орост нэвтэрсэн сургалтын багц цагийн (кредит цаг) тогтолцооны онцлог болсон технологийн картад тусгагдсан болно. Технологийн карт нь уг чанартаа тухайн аль нэг хичээлийг судлахад чиглэсэн хичээллэх (сургалтын) үйл явцын (оюутны төрөл бүрийн үйл ажиллагааны зохион байгуулалтын) төсөл, гүйцэтгэх ажлын цар хэмжээ, төрөл, хугацаа, үнэлгээний шалгуур багш, оюутны хэн хэнд нь адилхан ойлгогдох төсөл юм. Технологийн карт нь

хичээлийн агуулгыг болон шаардлагатай мэдлэг эзэмших, чадамж төлөвшүүлэхээр зорьсон чиг шугамаасаа эргэж буцах, хазайхгүй байхад туслах луужин болох учиртай.

Багш нь технологийн картыг боловсруулж, бие даалтын ажлын даалгавар зохиохдоо оюутны бодит боломж, тэдний бие даан ажиллах хөгжлийн болон шаардлагатай мэдлэг эзэмшилтийн түвшин зэргийг харгалзаж, даалгаврыг хүндрүүлэх тогтолцоонд оруулах замаар бие даалтын ажлын түвшнийг аажмаар дээшлүүлэх, оюутны танин мэдэх сонирхол, хувийн онцлогийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх ёстой.

Багшлах боловсрон хүчнийг олон шатлалт тогтолцоогоор бэлтгэх ажлыг он удаан жилийн туршид хэрэгжүүлж буй А.И.Герценний нэрэмжит Оросын сурган хүмүүжүүлэх ухааны улсын их сургуулийн хүүхэд судлалын хүрээлэнд оюутны бие даалтын ажлыг зохион байгуулах, оюутны үйл ажиллагааг удирдах хэрэгсэл болсон технологийн карттай ажиллах тогтолцоо бүрэлдэж тогтсон юм. Өмнө нийтлүүлсэн өгүүлэлд магистрын диссертаци бэлтгэхэд магистрантуудын бие даалтын ажлын зохион байгуулалтад технологийн карт ашиглах тухай авч үзсэн (Вергелес, Граничина, 2012).

Хичээлийг (модуль) судалж эзэмшихэд чиглэсэн технологийн картын бүтэц, агуулга ямар онцлогтой вэ?

Нэгд, хичээл, хөтөлбөрийн нэр, түүний статус (тухайн хичээл ямар бүлэгт (ерөнхий суурь, мэргэжлийн, мэргэшэх) хамаарах), дамжаа, судлах улирал, хөдөлмөр зарцуулалт (тухайн хичээлийг танхимд судлах болон бие даалтын ажил гүйцэтгэхэд ногдох цагийн тоог бүхэлд нь заасан), тооцох нэгжийн тоо (кредит), явцын шалгалтын хэлбэр, диплом авахад шаардагдах үнэлгээний онооны тоо хэмжээ болон боломжит дээд хязгаар зэргийг дурдах ёстой.

Тухайн хичээлийн талаарх ийм мэдээлэл оюутныг ажиллах чиг баримжаатай болгож, гүйцэтгэлийн явцыг урьдчилан харах боломжийг түүнд олгоно.

Хоёрт, технологийн картад хичээлийн төрөл, оюутны гүйцэтгэх ажил (заавал гүйцэтгэх, нэмэлтээр гүйцэтгэх)-ыг заана. Ингэж зааснаар оюутан гүйцэтгэх ажлаа бүрэн ухамсарлаж, тодорхой хэмнэлтэйгээр, ойрын болон хэтийн төлөвийг харж, авах ёстой үнэлгээний боломжит үр дүнг урьдчилан тооцоолох, шаардлагатай гэж үзвэл хүссэн үнэлгээний оноо авахын тулд нэмэлт даалгавар гүйцэтгэхээр төлөвлөх боломжтой болно. Ажлын төлөвлөлт, үр дүнд хүрэх хувилбарын эрэл хайгуул нь бие даалтын

ажлын амжилтыг хангах, үйл ажиллагаагаа өөрөө зохион байгуулах үндсийг бүрдүүлэх нь дамжиггүй. Технологийн карт боловсруулахдаа ном зохиолын нийгээд Интернет эх сурвалжтай ажиллах, харьцуулсан хүснэгт зохиох, багшлах (сурган хүмүүжүүлэх) явцад тохиолдох төрөл бүрийн нөхцөлүүдэд болон гаргах шийдвэрүүдэд шинжилгээ хийх, бага сургууль дахь боловсролын үйл явцын төсөл, загвар зохиох, багшлах (сурган хүмүүжүүлэх) үйл ажиллагааны элементүүдээс боловсролын бодит үйл явцад хэрэгжүүлэх, эрдмийн судалгаа шинжилгээний ажлыг төлөвлөж явуулах зэрэг бусад олон ажлыг багтаасан төрөл бүрийн даалгаврыг гүйцэтгэхэд өөрийгөө бүрэн дүүрэн дайчлахуйцаар бодолцсон нөхцөлд мэргэжилтэн бэлтгэх үндсийн үндэс нь оюутны бие даалтын ажил байхаар харгалзана. Заавал гүйцэтгэх даалгаврын нэг нь практик хичээлийн төлөвлөгөөний дагуу асуудлыг хэлэлцэх, хичээл дээрх идэвхтэй ажиллагаа бөгөөд ингэх боломж хичээлээс гадуурх бие даалтын ажлаар хангагдан бүрдэнэ.

Гуравт, технологийн картад тухайн хичээлийн хөтөлбөрт яв цав нийцүүлэн зохиосон, хичээлийн сэдэв, судлах хугацаа, заавал гүйцэтгэх ажлын төрөл, даалгавар гүйцэтгэсэн тохиолдолд авах онооны тоо хэмжээ зэргийг заасан аргазүйн зөвлөмж бүхий календарьчилсан төлөвлөгөө багтана. Календарьчилсан төлөвлөгөө нь оюутны үйл ажиллагааг эмх цэгцтэй болгож, өөрийнхөө ажлыг тодорхой логиктой эрэмбэлэхэд сургана.

Дөрөвт, технологийн картад заавал хийгээд нэмэлтээр гүйцэтгэх даалгаврын гүйцэтгэлийн шалгуурууд, хэрэв шаардлагатай бол тэдгээр даалгаврыг бэлтгэхэд тавих шаардлагууд байна. Даалгаврыг гүйцэтгэхээс өмнө уг даалгавар хэрхэн үнэлэгдэх, юуг илүү ач холбогдолтойд авч үзэх зэргийг урьдчилан харах боломж нь удирдлагын эхлэл болж, түүнд тэмүүлэх сэдлийн түвшнийг бий болгоно. Тухайлбал, бага ангийн багш нарын заах аргын нэгдлийн хуралд “Бага сургуулийн сурагчдад суралцах үйл ажиллагаа төлөвшүүлэхэд багшийн гүйцэтгэх ажил” сэдвээр танилцуулга (презентаци) хийж үзүүлэх даалгаврыг магистрантуудад санал болгоно. Үнэлгээний шалгуурыг дараах байдлаар санал болгоно. Үүнд: Асуудын нэн чухлыг баталж нотолсон үндэслэлийн тоо: 2 - 1 оноо, 3 - 2 оноо, 3 - 3 оноо, 4 - 4 ба түүнээс дээш оноо.

Агуулгыг бүрэн дүүрэн гаргасан байдал: сэдвийн чухал талыг бүрэн дүүрэн гаргаж чадаагүй - 1 оноо, сэдвийн тодорхой асуудлыг дэлгэрүүлж чадаагүй - 2 оноо, агуулгыг бүрэн дүүрэн харуулж чадсан - 3 оноо.

Сонсогчдын онцлогийг харгалзсан байдал: сонсогчдын онцлогийг хэсэгчлэн харгалзсан - 1 оноо, бүрэн дүүрэн бус - 2 оноо, бүрэн дүүрэн - 3 оноо.

Танилцуулга дахь агуулгын оновчтой байдал, логик: танилцуулгын материал хангалттай бус бүтэцчилэгдсэн - 1 оноо; оновчтой, логиктой - 2 оноо.

Танилцуулгын техник чимэглэлийн онцлог: 2-3 арга хэлбэрийн чимэглэл ашигласан - 0,5 оноо, 4-5 арга хэлбэрийн чимэглэл ашигласан - 1 оноо, таваас дээш арга хэлбэрийн чимэглэл ашигласан - 2 оноо.

Танилцуулгын агуулгыг бэлтгэхэд төрөл бүрийн арга хэрэгсэл ашигласан байдал: зөвхөн текст ашигласан - 1 оноо, схем, хүснэгт, зураг ашигласан - 2 оноо, анимаци ашигласан - 4 оноо.

Өөр нэг жишээ авъя. “Бага сургуулийн сурагчдын суралцах үйл ажиллагаа төлөвших тогтолцоо” хичээлээрхяналт-шалгалтын материал боловсруулахдаа магистрантуудын боловсруулах даалгавар нь тухайн хичээлээр үзэж судалсан бүх сэдвийг хамарсан байх, шинж байдлын хувьд өөр өөр даалгавар оруулах, даалгаврын төрөл тус бүрийн үнэлгээний шалгуурыг дэлгэрүүлж бичих, даалгавар гүйцэтгэх хугацаа тодорхой байх, даалгаврыг шалгах түлхүүртэй байхаар ерөнхий шаардлагуудыг санал болгосон. Бэлтгэсэн материалыг үнэлэхдээ дараах шалгуурыг ашигласан.

Хичээлийн агуулгыг бүрэн дүүрэн харуулсан байдал: хичээлээр үзсэн сэдвийн тэн хагасаас багыг хамарсан - 1 оноо, хичээлээр үзэж судалсан сэдвийн ихэнхийг оруулсан - 3 оноо, сорилын даалгаварт хичээлээр үзсэн бүх сэдвийг оруулсан - 5 оноо.

Даалгаврын олон талт байдал: шинж байдлын хувьд 3 өөр даалгавар оруулсан - 1 оноо, шинж байдлын хувьд 4 өөр даалгавар оруулсан - 2 оноо, шинж байдлын хувьд 5 өөр даалгавар оруулсан - 3 оноо, шинж байдлын хувьд 5-аас дээш өөр даалгавар оруулсан - 4 оноо.

Даалгавар гүйцэтгэх шалгуурын тайлбар бичсэн байдал: шалгуурын заримыг онцолсон - 1 оноо, шалгуурын иж бүрдэл бүрэн хангалттай, тэдгээрийг нэгбүрчлэн тайлбарлаж бичсэн - 2 оноо, материалыг шалгах түлхүүрийн тайлбар: бүрэн, алдаагүй - 1 оноо.

Даалгаврыг гүйцэтгэхээс өмнө магистрант онцолсон шаардлага, үнэлгээний шалгуур зэргийг баримжаалан өөрийнхөө бие даалтын ажлыг илүү зорилго чиглэлтэй зохион төлөвлөж байгааг ажиглахад түвэггүй.

Практикийн хичээл дээр асуудал хэлэлцэх үнэлгээний шалгуурын талаар оюутнуудын мэдлэг чухал гэдгийг онцгойлох хэрэгтэй бөгөөд практикийн хичээлд бэлтгэх нь материалыг эмх цэгцтэй (системтэй) эзэмших, бүхий л улирлын туршид хичээлийн агуулгыг судлахдаа бие дааж ажиллахыг оюутнаас шаардана.

Үнэлгээний боломжит хувилбарын нэг нь тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, маргаан, ажил хэргийн тоглоом гэх мэтэд оролцсон байдал, гаргасан идэвх зэргийг харгалзах явдал байж болох юм.

Хичээл дээр оюутны гүйцэтгэсэн ажлын үнэлгээний амжилт бүлэг дэх оюутны тооноос хамаарах нь гарцаагүй (цөөхөн хүнтэй магистрын бүлэгт хичээлд бэлтгэхдээ гэртээ бие даан гүйцэтгэсэн ажлын чанар, бэлэн байдлын хэр хэмжээг илүү нарийн, хангалттай үнэн зөв үнэлж болдог). Хичээл дээрх бакалаврын оюутны үнэлгээнд онцгой анхаарах хэрэгтэй бөгөөд бүх оюутан (хичээл дээр идэвх гаргадаг цөөхөн оюутан бус) тодорхой тоо хэмжээний оноо “авах” даалгавар (нэр томъёо, ухагдахуун эзэмшил, сурган хүмүүжүүлэх зорилтыг шийдвэрлэхэд санал болгох тухайн асуудлаарх ерөнхий чиг баримжааг шалгах таваас - долоон минутад багтах бичил хяналтын ажил гэх мэт) ашиглахыг шаардана.

Тавд, бие даалтын ажлын амжилт оюутанд даалгавар гүйцэтгэхэд нь тодорхой хэмжээгээр сонголт хийх эрх чөлөө, өөрийнхөө сонирхолд нийцүүлж ажиллах боломж олгохоос олон талаар хамаарна.

Тухайлбал, илтгэл бэлтгэх, дипломын болон магистрын ажилд шүүмж бичих, сургуульд бичил судалгаа хийх, судалж байгаа хичээлээр хяналт - шалгалтын материал бэлтгэх гэх мэт даалгавар өгч байгаа бол сонголт хийхэд хангалттай гүйцэтгэх ажлын сэдэв, жагсаалт гаргана.

Зургаад, бие даалтын ажлаар гүйцэтгэсэн бүх даалгаврын хяналт - шалгалт цаг алдахгүй байх аваас технологийн карт оюутны бие даалтын ажлын зохион байгуулалтын хэрэгсэл болж чадна. Хяналт - шалгалтын явцад анхаарлыг гүйцэтгэсэн ажлын үр дүнгээс (бөглөсөн хүснэгт, шийдвэрлэсэн сурган хүмүүжүүлэх зорилт) гадна тухайн бие даалтын ажлыг гүйцэтгэхэд бодитой хэрэгжүүлсэн үйлдлүүдэд төвлөрүүлэх учиртай. Ингэвэл даалгаврыг гүйцэтгэхэд илүү боломжит арга замыг ашиглах боломжийг багшид олгоно.

Технологийн картад мөн тухайн хичээлийн хөтөлбөрт тусгасан бүхий л агуулгыг оюутан хэр зэрэг эзэмшсэнийг харах боломжтой хяналтын

ажлын багц даалгавар (сорилын даалгавар, төсөл боловсруулах гэх мэт) багтах бөгөөд тухайн ажлыг гүйцэтгэх хугацаа, зохион байгуулах онцлог зэргийг технологийн картад зааж тусгана. Тухайн хичээлийг судалж эхлэхэд оюутнууд тухайн төрлийн ажил хэрхэн үнэлэгдэх, түүний гүйцэтгэл бүхий л улирлын туршид хийж гүйцэтгэх бие даалтын ажлын амжилтаас ямар хэмжээгээр хамаарахыг олж харах болно.

Технологийн картыг олон жил ашиглахдаа бид бие даалтын ажлын зохион байгуулалтад ямар үүрэгтэй болохыг магистрантууд хэрхэн үнэлдэг болохыг олж тогтоохыг хичээсэн болно. 43 магистраас асуулга авсан болно. (нэгдүгээр дамжааны 32, хоёрын 11) “Таны бие даалтын ажлын зохион байгуулалтад технологийн карт дэмжлэг үзүүлж чадсан уу? Яагаад?” гэсэн асуултад асуулгад оролцсон бүх хүн 100% эерэг хариулт өгсөн бөгөөд технологийн карт өөрийн үйл ажиллагааг зохион байгуулах, гүйцэтгэх бүх ажлын хэмжээг урьдчилж харах, гүйцэтгэх хугацааг нарийн баримжаалах, боломжийг олгож байгаа; тайлбарласан шалгуурууд ажлын гүйцэтгэлийн чанарт илүү чанга хандах боломж олгож байгаа, тооцох үнэлгээний оноо гэнэтийн биш байгаа зэргийг дурдсан байна.

Хоёр дахь асуулт технологийн картыг магистрантуудын бие даалтын ажлын зохион байгуулалтын хэрэгсэл үнэхээр болгохын тулд түүнд өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхэд хамаарсан. Асуулгад хамрагдсан магистрантуудын 58% нь технологийн карт өөрчлөлт оруулахгүйгээр үүргээ хангалттай биелүүлж байгаа гэж үзсэн байна. Нэгдүгээр дамжааны магистрантуудын дэвшүүлсэн саналын тоонд даалгавар гүйцэтгэх загвар, даалгавар гүйцэтгэхэд тусламж болох ном зохиол болон Интернет сайтын жагсаалт хэрэгтэй гэсэн байв. Энэ нь нэгдүгээр дамжааны магистрантуудын зарим нь хэрэгтэй мэдээллийг эрж хайх, даалгавар гүйцэтгэхэд тавих шаардлагыг үндэслэн бие дааж ажиллах, үнэлгээний шалгуурыг үр дүнд хүрэх баримжаа болгох чадварыг бүрэн дүүрэн эзэмшээгүй болохыг гэрчилж байна.

Хоёрдугаар дамжааны магистрантууд картын бүтцэд нэгдмэл хандлага хэрэгтэй, гүйцэтгэсэн ажлыг танилцуулах хугацааг хатуу чанга болгох (оюутнууд назгайрахгүй, багш нар хэмнэлтэй ажиллахын тулд), даалгавар гүйцэтгэх явцад багшаас асуух, ажлынхаа үр дүнг илүү шуурхай олж мэдэхийн тулд блог бий болгохын чухлыг онцолсон байв.

Технологийн картыг ашигласнаар оюутнуудын бие даалтын ажлыг удирдах нөхцөл бүрдүүлж, түүнийг хэмнэлтэй болгож, хувийн зохион байгуулалтад сургаж, бие дааж системтэй ажиллах сэдэл тэмүүлэл төлөвшихөд тус дөхөм үзүүлж, суралцагчдын хувийн боломж, сонирхлыг харгалзах боломж олгож, тохиолдлоор эцсийн үнэлгээ гаргах явдлыг бууруулж байна.

#### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Трапицына, А.П., Радионова Н.Ф. (2008). Уровневое образование при подготовке педагогических кадров, *Аккредитация в образовании*, 22.

Вергелес, Г.И., (2011). Подготовка учителя начальных классов: Федеральный государственный стандарт третьего поколения, Герценовские чтения. *Начальное образование*. Том 2. Вып. 1. Санкт-Петербург: ВВМ.

Граничина, О.А., Трапицын, С.Ю. (2007). Построение модели системы комплексного оценивания качества деятельности вуза с использованием процессного подхода. *Известия Российского государственного педагогического университета им. А.И. Герцена*, 9.

Граничина, О.А., Онищенко, Э.В. (2012). Обеспечение качества подготовки педагога начальной школы: проблемы и перспективы. *Герценовские чтения. Начальное образование*. Том 3. Вып. 1. Санкт-Петербург: ВВМ.

Вергелес, Г.И., Граничина, О.А., Онищенко, Э.В. (2012). Оценка качества работы магистрантов по подготовке диссертации в свете ФГОС третьего поколения. *Герценовские чтения. Начальное образование*. Том 3. Вып. 2. Санкт-Петербург: ВВМ.

Федеральный государственный образовательный стандарт высшего профессионального образования. [Электронный ресурс]. Режим доступа: [http://www.edu.ru/db-mon/mo/Data/d\\_09/prm788-1.pdf](http://www.edu.ru/db-mon/mo/Data/d_09/prm788-1.pdf)

Орчуулсан: Д. Энхээ, магистр, МУБИС  
Б. Мягмаржав, докторант, МУБИС